



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО**

**2021**

**МОНГОЛ УЛСАД ДАХИН ДАМЖИГДАЖ БАЙГАА ГАДААД  
СУВГУУДЫН БҮРТГЭЛ**



**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

Өргөн нэвтрүүлгийн  
зохицуулалтын газар

## ОРШИЛ.

Мэдээллийн хурдацтай хөгжлийн эрин үед айл өрхийн хүлээн авч буй телевизийн сувгийн тоо улам олширч, тэр хирээр дотоод, гадаадын төрөл бүрийн хөтөлбөр, мэдээллийн их урсгалыг хүлээн авах боломж нээгдсээр байгаа билээ.

Телевиз нь бусад мэдээллийн хэрэгслүүдтэй харьцуулахад айл гэрийн хойморт урилгагүй зочилж, дэлгэцийн урд хэн сууж байгаагаас үл хамааран гэр бүлийн бүх хүмүүст үзэх боломжийг олгож байдгаараа онцлог мэдээллийн хэрэгсэл билээ. Иймд улс орон бүр үндэсний болон нийтийн эрх ашиг, хүүхдийн эрхийг хамгаалахад онцгой анхаардаг бодлого, зохицуулалт зайлшгүй шаардагддаг салбар юм.

Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд радио, телевизийн газрын сүлжээний үйлчилгээ болон нийт 34 олон суваг дамжуулах үйлчилгээний эрхлэгчдийн сүлжээ, үйлчилгээгээр дамжуулан хэрэглэгч олон нийт дотоодын 161 тусгай зөвшөөрөлтэй телевизийн суваг мөн гадаадын дахин дамжуулагдаж байгаа телевизийн сувгуудын хөтөлбөрийг хүлээн авч байна.

Эдгээр Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа телевизийн үйлчилгээ эрхлэгчдийн хувьд Харилцаа холбооны зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхэлж, тодорхой хяналт зохицуулалттай явж ирсэн ч гадаадын дахин дамжигдаж байгаа олон тооны телевизийн сувгуудын хувьд албан ёсоор бүртгэлгүй, тодорхой зохицуулалт, мэдээлэлгүй явж ирсэн юм.

Монгол улсад Өргөн нэвтрүүлгийн тухай хууль 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдөр батлагдаж, 2020 оны 7 сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээр өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгчдийн эрхзүй, зохицуулалтын орчин тодорхой болж, хуульд заасан зохицуулалтын холбогдох арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна.

Өргөн нэвтрүүлгийн тухай хууль батлагдан гарснаар олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид гадаад улсын радио, телевизийг дамжуулахдаа албан ёсны эрхийг авч, Зохицуулах хороонд бүртгүүлсэн байх үүрэг хүлээсэн бөгөөд гадаад сувгуудын хөтөлбөр нь мөн Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байна гэж заасан болно.

Иймд Харилцаа холбооны зохицуулах хорооны зүгээс хуульд заасан эрх, чиг үүргийн хүрээнд Монгол улсад дахин дамжигдаж байгаа гадаад улсуудын сувгуудыг бүртгэх ажлыг 2021 онд зохион байгуулж, бүртгэлийг гаргаад байна.

## ЭРХЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.


Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа радио, телевизийн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу олон суваг дамжуулах үйлчилгээг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрөлтэй эрхэлж, Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, Радио долгионы тухай хууль зэрэг салбарын болон холбогдох бусад хууль тогтоомжуудад заасан үүрэг хариуцлага хүлээж ажилладаг болно.

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 26 дугаар зүйлд Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд тавигдах тухайн үйлчилгээтэй холбоотой онцлог шаардлагыг хуульчилсан бөгөөд 26 дугаар зүйлд

- 26.1-т “Гадаад улсын радио, телевизийг дамжуулахдаа албан ёсны эрхийг нь авсан, Зоцуулах хороонд бүртгүүлсэн байх бөгөөд хөтөлбөр нь Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, эрх ашигт харшлахгүй байна”;
- 26.2-т “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгч нь радио, телевизийн хөтөлбөрийг гэрээний үндсэн дээр дамжуулна” гэж тус тус заасан

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 24 тоот тогтоолын хавсралтаар баталсан “ Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага”-ын 5 дугаар зүйлд гадаад улсын телевизийн сувгийг дамжуулахтай холбоотой дараах шаардлагууд тавигдсан.

## Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага



Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.4-т заасан эрх, үүргийн дагуу “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага баталж, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй.

Иймд Харилцаа холбооны зохицуулах хороо нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуульд заасан эрх, чиг үүргийн хүрээнд Монгол улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа гадаад сувгуудыг бүртгэх ажлыг 2021 онд хийж гүйцэтгэсэн болно.

## ГАДААД СУВГИЙГ БҮРТГЭСЭН ТУХАЙ.

Харилцаа холбооны зохицуулах хороо нь Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгийг бүртгэхдээ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагад заасан шаардлагын хүрээнд бүртгэлийн маягт гаргаж, бүртгэх ажлыг зохион байгууллаа.

### Гэрээтэй байх:

Өргөн нэвтрүүлгийн тухай хуулиар олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид нь гадаад улсын радио, телевизийг дамжуулахдаа албан ёсны эрхийг нь авсан байх шаардлага тавигдаж байгаа тул Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны өмчийн газрын даргын 2021 оны А/26 - А/13 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар “Гадаад улсын телевизийн сувгийг дамжуулахад бүртгүүлэх өргөдлийн маягт” батлан гаргасан.

Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээс “Гадаад улсын телевизийн сувгийг бүртгүүлэх тухай” хүсэлт, материалыг тус маягтын дагуу хүлээн авч, хянасан бөгөөд гадаад сувгуудыг дахин дамжуулах гэрээг эрх бүхий байгууллагатай байгуулсан эсэхийг үйлчилгээ эрхлэгч нэг бүр дээр очиж гэрээг шалгаж бүртгэлийг хийсэн болно.

Ийнхүү Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн дагуу Монгол Улсад дахин дамжуулж байгаа гадаад улсын сувгуудыг бүртгэх ажил нь анх удаагаа хийгдэж байгаа ажил бөгөөд бүртгэл хийгдсэнээр өнөөдөр манай улсад ямар улсын, ямар төрөл хөтөлбөртэй, хэдэн гадаад сувгийг дахин дамжуулж байгаа, тэдгээр нь гэрээтэй, гэрээгүй эсэх мэдээллүүдийг нэгтгэж, ил тод мэдээлэх боломж бий болж байна.

Гадаад улсын телевизийн сувгийг бүртгэхдээ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын дагуу дараах мэдээллүүдийг авсан. Тухайлбал:

- Дахин дамжуулж байгаа гадаад сувгуудын жагсаалт, тухайн сувгийн нэр
- Сувгийн эрхийг эзэмшигч этгээдийн нэр;
- Эзэмшигчийн харъяалал улсаар;
- Гадаад сувгийг дамжуулах эрхийг олгосон буюу гэрээ байгуулсан этгээдийн мэдээлэл;
- Олгож байгаа эрх;

- Дахин дамжуулах эрх олгосон эсэх (гэрээтэй эсэх);
- Төлбөрийн нөхцөл;
- HD, SH, сигналын эх үүсвэр;
- Сувгийн төрөлжилт, чиглэл;
- Сувгийн хөтөлбөр ямар хэлээр нэвтрүүлдэг гм.


## ГАДААД СУВГИЙН БҮРТГЭЛ

Монгол Улсад 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар Улаанбаатар хотын 12, аймаг, орон нутагт 22, нийт 34 олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид өөрийн үндсэн болон нэмэлт багцууддаа гадаадын телевизийн сувгуудыг дахин дамжуулж байна.

### Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн дахин дамжуулж байгаа гадаад сувгуудыг бүртгэсэн байдал.

Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх нийт 12 тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаагаас 2021 оны 12-р сарын 31-ний байдлаар 11 тусгай зөвшөөрөл эзэмшигчид үндсэн болон нэмэлт багцууддаа нийт **29** орны **199** гадаад суваг дахин дамжуулж байна.

### Нийт гадаад сувгийн тоо



Улаанбаатар хот. Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид

### Дахин дамжуулж байгаа гадаад улсын харьяалал.


Монгол улсад олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдийн сүлжээгээр дахин дамжуулж байгаа сувгуудыг авч үзэхэд 1 үйлчилгээ эрхлэгч дунджаар 44 гадаад суваг, хамгийн багадаа 9, хамгийн ихдээ 111 суваг дамжуулж байгаагаас гадаад улсын харьяаллыг улсаар авч үзэхэд нийт 29 улс (**БНХАУ-ын Өвөр монголын телевизийн сувгийг хэлний ялгаатай байдлыг харгалзан нийт тоонд оруулаагүй, хүснэгтэд тусад нь харуулсан болно**) байна.

Гадаад сувгийн тоо, улсын харьяаллыг олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдээр нь үзүүлбэл:

Гадаад сувгийн бүртгэл	ДДЭШ ТВ	MNBC	Моби-нет	Монгол сат	МЦХ	Оптимум	Сансар дижитал	Скай медиа	Талст	Шинэ сансар	Юнивишн
Нийт гадаад сувгийн тоо	57	50	9	36	31	46	18	58	27	44	111
Гадаадын сувгийн улс, харьяалал	13	15	2	10	8	16	8	15	7	13	21


Монгол улсад дахин дамжуулагдаж байгаа гадаад улсуудыг жагсаалтаар харуулбал:

№	Гадаад улсын харьяалал	Нийт дамжигдаж байгаа сувгийн тоо	№	Гадаад улсын харьяалал	Нийт дамжигдаж байгаа сувгийн тоо
1	Австрали	1	16	Люксембург	1
2	Австри	1	17	Макао	1
3	АНУ	40	18	ОХУ	64
4	Араб	1	19	БНХАУ (Өвөр монгол)	1
5	БНСУ	3	20	Пакистан	4
6	БНХАУ	28	21	Польш	1
7	Болгар	1	22	Португал	1
8	Герман	5	23	Сингапур	1
9	Испани	2	24	Турк	1
10	Итали	2	25	Украйн	1
11	Их Британи	7	26	Франц	9
12	Канад	1	27	Хонконг	1
13	Казакстан	5	28	Швед	3
14	Катар	1	29	Энэтхэг	4
15	Латви	1	30	Япон	7
	Нийт харьяалал		<b>29</b>		
	Нийт гадаад суваг	199			



Гадаад сувгуудын улсын харьяаллыг авч үзэхэд нийт 199 сувгийн 66 %-д нь ОХУ, АНУ, БНХАУ-ын телевизийн суваг хамаарч байна.

Гадаад сувгуудын харьяалах улс орныг нийт гадаад сувагт эзлэх хувиар авч үзэхэд:



Нийт гадаад сувгуудад эзэлж байгаа бусад улсын 10 %-д Испани, Итали улсын тус тус 2 суваг, бусад 16 улс орны тус тус 1 суваг хамаарч байна.


Үндсэн багцад эзлэх гадаад сувгийг авч үзэхэд

Гадаад сувгийн бүртгэл	ДДэ шТВ	MNBC	Мобинет	Монголсат	МЦХ	Оптимум	Сансар дижитал	Скай медиа	Талст	Шинэ сансар	Юнившн
Үндсэн багц: Монгол суваг	57	56	23	60	54	48	41	23	36	44	59
Үндсэн багц: Гадаад суваг	39	28	0	24	31	7	19	0	27	26	44
Үндсэн багцын гадаад сувгийн хувь	41%	33 %	0	29%	36%	13%	32%	0	45%	37%	43%
Нэмэлт төлбөртэй гадаад сувгийн тоо	16	20	9	7	4	11	0	10	0	0	17
Нийт гадаад сувгийн тоо	57	50	9	36	40	41	18	58	27	44	111

Гадаад сувгуудыг гэрээ байгуулж дамжуулсан байдал.


№	Гадаад сувгийн бүртгэл	Мобинет	Ддэш ТВ	MNBC	Юнившн	Скаймедиа	Монголсат	Шинэ сансар	МЦХ	Оптимум	Талст	Сансар дижитал
1	Нийт гадаад сувгийн тоо	9	57	50	111	58	36	44	31	46	27	18
2	Гэрээтэй	9	49	40	88	36	15	8	4	0	0	0
3	Гэрээгүй	0	8	10	23	22	21	36	27	46	27	18





**Гэрээгүй**

10 ОСДҮЭ-ийн хувьд 14%-100 % хүртэл гэрээгүй байна.




**Гэрээтэй**

8 ОСДҮЭ-ийн хувьд 13%-100 % (9 сувагтай) хүртэл гэрээ байгуулсан



Гадаад сувгийн гэрээг 100 % байгуулсан ОСДҮЭ-ийн хувьд гадаад сувгийн тоо -9, ДДэш ТВ, MNBC, Юнивишн ХХК, Скаймедиа ХХК-ийн хувьд дамжуулж байгаа сувгийн тоо 50-111 суваг, эдгээрийн 60-86 % хүртэл хувь гэрээтэй. Гэрээгүй сувгийн хувьд гэрээ байгуулах шатанд явж байгаа сувгууд мөн байсан.




Гадаад сувгуудын хэлний тухайд:

Монгол улсад дахин дамжуулж байгаа 119 гадаад сувгуудыг ямар ямар хэл дээр дамжигдаж байгааг авч үзэхэд

## Гадаад сувгуудын хэл

### НИЙТ 25 ХЭЛЭЭР



### ГАДААД СУВГУУДЫН ДАМЖИГДАЖ БАЙГАА ХЭЛ

№	Дамжигдаж байгаа хэл	Нийт сувгийн тоо	Эзлэх хувь
1	Англи	97	41%
2	Орос	80	33%
3	Хятад	23	10%
4	Япон	7	3%
5	Орос/Англи	6	3%
6	Урду	6	3%
7	Франц	6	3%
8	Солонгос	3	1%
9	Энэтхэг	3	1%
10	Араб	2	1%
11	Герман	2	1%
12	Испани	2	1%
13	Итали	2	1%
14	Казак	2	1%
15	Өвөрмонгол	1	0%
16	Англи Орос Казак	1	0%
17	Орос, Тува	1	0%
18	Португал	1	0%
20	Тамил	1	0%
21	Турк	1	0%
22	Уйгар	1	0%
23	Украйн	1	0%
24	Унгар	1	0%
25	Итали	2	1%
	Нийт	25	

Монгол Улсад дахин дамжуулж байгаа гадаад сувгуудын хөтөлбөрийн төрөл, жанрыг гаргахдаа олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчидтэй байгуулсан гэрээ


болон тэдний маягтаар ирүүлсэн мэдээлэлд үндэслэн гаргасан бөгөөд Зохицуулах хороо нь гадаад сувгуудын хөтөлбөрийн агуулгыг хянах, хууль зөрчсөн эсэхийг тогтоох, төрөл жанрыг тодорхойлох чиг үүрэг байхгүй болно.

## Гадаад сувгуудын хөтөлбөрийн төрөл

№	Төрөл	Сувгийн тоо	Эзлэх хувь
1	Интертеймент	44	14%
2	Мэдээний	42	13%
3	Танин мэдэхүй	33	10%
4	Аялал жуулчлал	32	10%
5	Кино	27	8%
6	Олон талт	27	8%
7	Хүүхдийн	19	6%
8	Спорт	17	5%
9	Нийгэм эдийн засгийн	13	4%
10	Ахуй соёл	12	4%
11	Баримтад	10	3%
12	Хөгжим	10	3%

№	Төрөл	Сувгийн тоо	Эзлэх хувь
13	Боловсрол	9	3%
14	Үндэсний	9	3%
15	Байгаль экологи	6	2%
16	Түүхийн	3	1%
17	Насанд хүрэгчдэд	2	1%
18	Ан, агнуур	1	0%
19	Гэмт хэрэг	1	0%
20	Загварын	1	0%
21	Хоолны	1	0%
22	Худалдааны	1	0%

## Гадаад сувгуудын хөтөлбөрийн төрөл, жанр



Монгол улсад дахин дамжуулж байгаа гадаад сувгуудын дэлгэрэнгүй жагсаалтыг Харилцаа холбооны зохицуулах хороо, Оюуны өмчийн газрын даргын 2021 оны А/26 - А/13 дугаар хамтарсан тушаалын хавсралтаар баталсан “Гадаад

улсын телевизийн сувгийг дамжуулахад бүртгүүлэх өргөдлийн маягтын дагуу олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид тус бүрээр гаргасныг хавсаргав.